



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол улсын их сургууль,
Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Газар зохион байгуулалт

Индекс: D053211

Шинжээчийн баг:

Ахлагч:	С.Сайнбаяр
Гишүүд:	Б.Гантулга
	Ж.Даваабаатар

2018.02.22

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар.....	4
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	5-6
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	6
III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт	7-8
IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	9-37
Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	9-11
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	11-15
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	15-22
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	22-25
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	25-30
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	30-33
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	33-36
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	36-37
V. Оролцогчдын нэрс.....	38-40
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	
II. Оюутны нэр.....	
III. Ажил олгогч.....	
IV. Төгсөгчид.....	
VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	
VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
МУИС	Монгол улсын их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
АЭС	Агроэкологийн сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
СиСи	Мэдээлэл технологийн систем
ШУС	Шинжлэх ухааны сургууль
БУС	Байгалийн ухааны салбар
GPS	Газарзүйн байршил тогтоогч
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ГГС	Геологи газарзүйн сургууль
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам
ОУ	Олон улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
БИС	Байгалийн их сургууль
ИТС	Инженер технологийн сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ТИ	Технологийн их сургууль
ИС	Их сургууль
ГЗБ	Газар зохион байгуулалт
ОХУ	Оросын холбооны улс
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУ	Шинжлэх ухаан
ГХ	Газрын харилцаа
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕШ	Ерөнхий шалгалт
СА	Сургалтын алба
PPT	Power point program
ОА	Оюутны алба
МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
ЭЗ	Эдийн засаг
БХТ	Багш хөгжлийн төв
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Газар зохион байгуулалт Land management	
Индекс	D053211	
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. С.Сайнбаяр. ХААИС-ийн АЭС-ийн газрын менежментийн тэнхимийн эрхлэгч Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. Б.Гантулга. ШУТИС-ийн багш 3. Ж.Даваабаатар. Монголын газар зохион байгуулагчдын холбооны дэд ерөнхийлөгч	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2018-01-17	№76 Ажлын албаны захирлын тушаалаар Шинжээч томилогдсон.
	2018-01-22	№01/18 Шинжээчидтэй гэрээ байгуулсан.
	2018-01-22	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хүлээн авч, танилцсан.
	2018-02-02	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	2018-02-05	Зохицуулагч сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулсан.
	2018-02-08,09	Сургууль дээр ажиллаж, илрэл нотолгоотой танилцсан. Төгсөгчид, ажил олгогч, багш, оюутнуудын төлөөлөлтэй уулзсан.
	2018-02-22	Шинжээчид үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгсөн.
	2018-02-26	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авсан.
	2018-03-05	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг зохицуулагчид хүлээлгэн өгнө.
	2018-03-06	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	2018	Мэргэжлийн зөвлөлийн хурлаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт БМИҮЗ-ийн дүрмийн 2.1-ийн “б” заалт, БМИҮЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2.9-2.2.18 заалт, БМИҮЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур”,
----------------------------------	--

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Газар зүйн салбар нь 1956 онд МУИС-ийн Байгалийн ухааны факультетад Газарзүйн тэнхим болон байгуулагдсанаас хойш 42 жилийн дараа 1995 оноос Газарзүй Геологийн факультет гэсэн статустайгаар бие даан өргөжин хөгжиж байна. 2009 онд Газарзүй Геологийн факультетыг Газар зүй Геологийн сургууль болгон өөрчлөн нэрлэсэн. 2013 оноос тус факультетыг татан буулгаж шинээр Шинжлэх ухааны сургууль, түүний харьяа Газарзүйн тэнхим болгон өөрчлөн зохион байгуулсан.

1997 оноос эхлэн газарзүйн мэргэжлийн хөтөлбөрөөс тусгаарлаж, “Газар зүйч, газрын менежмент” чиглэлээр сургалт явуулж эхэлсэн байна. Хөтөлбөрийг 1999, 2001, 2004, 2007, 2012, 2015 онд шинэчилж боловсронгуй болгосон байна.

1999 оноос “Газар зохион байгуулалт, менежмент” хөтөлбөрөөр 19 удаагийн төгсөлт хийж, бакалаврын зэрэгтэй 390 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн байна. 2017-2018 оны хичээлийн жилд 135 оюутан суралцаж байна. МУИС, ШУС-ийн захирлын 2015 оны 09 сарын 11-ны Б-101 тоот тушаалаар өөрийн үнэлгээний багийг 10 гишүүнтэйгээр байгуулсан. 2016 оны 03 сарын 10-ны өдөр магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанд өгч, 2016 оны 03 сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан байна.

III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт

МУИС-ийн ШУС-ийн ГАЗАРЗҮЙН ТЭНХИМИЙН “ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ӨГӨХ ТОДОРХОЙЛОЛТ

2017.12.18

МУИС-ийн ГТФ-ын деканы 2005 оны 09 сарын 30-ны 68 тоот тушаал, ШУС-ын захирлын 2017 оны 01 сарын 30-ны Б-17 тоот тушаалаар 13 гишүүн бүхий өөрийн үнэлгээний ба байгуулан боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлэх гэж буй бакалавр, магистрын зэрэг олгох МУИС-ийн ШУС-ийн “Газар зохион байгуулалт” хөтөлбөрийг анх 1998 онд баталсан бөгөөд 1999 оноос Газарзүйч-Газар зохион байгуулагч, 2002 оноос Газрын менежмент, 2013 оноос Газар зохион байгуулалтаар анхлан боловсролын зэрэг олгож эхэлжээ. Хөтөлбөрөөр нийт 19 удаа төгсөлтөөр 390 хүн төгсгөсөн бол 1999, 2001, 2004, 2007, 2012, 2015 онуудад шинэчилж боловсронгуй болгосон байна.

Өөрийн үнэлгээний тайлан (ӨҮТ) нь оршил, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх найман шалгуур шаардлагын дагуу бичиж ирүүлсэн үндсэн бүлгүүд, дүгнэлт гэсэн гурван хэсэгтэй аж. ӨҮТ дараах ажлын хүрээнд боловсруулсан байна.

1. Өөрийн үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт өгөх
2. Өөрийн үнэлгээг баталгаажуулах
3. Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй боловсронгуй болгох
4. Бэлтгэж байгаа мэргэжилтний мэдлэг, чадварыг сайжруулахад нөлөө үзүүлэх
5. Хөтөлбөртэй холбоо бүхий үйл ажиллагаануудыг олон нийтэд мэдээлэх, мэргэжилтэн бэлтгэх талаар хуримтлуулсан турпшагаа бусдад хүргэх

ӨҮТ-ийн 1, 2-р бүлэгт хөтөлбөрийн төлөвлөлт, хөтөлбөрийн хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл зэрэг хөтөлбөрийн орцын үндсэн үзүүлэлтийг авч үзсэн бол 3...6-р бүлэгт хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа, багшийн үйл ажиллагаа, сургалтын үйл ажиллагаа зэрэг хөтөлбөрийн явцын үзүүлтээр үнэлжээ. Тайлангийн 7 ...8 бүлэгт хөтөлбөрийн үр дүн, нөлөө, чанарын үнэлгээ баталгаажуулалт гэсэн үзүүлэлтийн дагуу тайланг бичжээ. Ингэхдээ тухайн хөтөлбөртэй холбогдох сүүлийн 3...5 жилийн мэдээллүүдийг ашиглан боловсруулалт хийж шалгуур үзүүлэлтийг гаргажээ. Чанарын удирдлагын PDCA мөчлөгийн арга,

зарчмыг баримтлан хөтөлбөрийн үйл явцыг үнэлж оноо өгчөө. Тус үнэлгээнд харгалзах мөчлөг, үйл явцыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөв байдлын ерөнхийг үнэлгээг тооцжээ.

ӨҮТ-г хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 8 шалгуурын дагуу бичихдээ өнөөгийн байгаа бодит байдалд үнэлэлт дүгнэлт өгч, давуу талаа тодорхойлон цаашид хэрхэн ахиц дэвшилт гаргах, сайжруулах тал дээр ач холбогдол өгч тусгаж өгсөн нь тайланг бодитой болгосон байна.

ӨҮТ-нд дараах зүйлсийг дэлгэрэнгүй тусгавал зохистой болох байжээ гэж үзэж байна.

Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал
- Сургалтын төлөвлөгөөний агуулга нь хүрэх дүнтэй уялдаж байгааг нотлох баримт бичиг
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын талаар дэлгэрэнгүй оруулах
- Хичээлийн стандарт дээрх хичээлээр олгох мэдлэг ур чадварыг дэлгэрэнгүй гаргаж хөтөлбөрөөр олгох мэдлэг ур чадвартай уялдуулах
- Хичээл бүрээр сургах арга хэлбэрийг илүү тодорхой болгох, тасралтгүй сайжруулах арга замыг бүрдүүлэх
- Хэрэв, хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой орц, явц, гарцтай холбоотой цаашид авах арга хэмжээ төлөвлөсний дагуу болохгүй бол яах вэ?

Эцэст нь дүгнэн хэлэхэд тус хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайлан нь дээд боловсролын хөтөлбөрийн 8 шалгуурын дагуу бүрэн бичигдсэн учир дараа дараагийн шатанд тайланг хүргүүлэх бүрэн боломжтой.

Тайлантай уншиж танилцсан :  док. дэд проф. К.Хавалболот

IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Өөрийн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх системтэй, салбарын хөгжилтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийг тасралтгүй боловсронгуй болгож газар зохион байгуулагч мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш 6 удаа шинэчлэгдсэн байна.
- Төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллаж төгсөгчдийн холбоо байгуулсан. Мөн төгсөгчдөд зориулсан давтан сургалтуудыг зохион байгуулдаг байна. Өнгөрсөн хугацаанд нийт 390 төгсөгч бэлтгэн гаргаснаас 57 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Гадаадын томоохон их сургуулиудтай хамтын ажиллагаа сайн хөгжсөн. Багш, оюутнуудыг гадны хөтөлбөр солилцоонд амжилттай хамруулдаг.
- Хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийг хийхдээ гадны Австралийн Квинслендийн их сургууль, БНХАУ-н Зейжан их сургууль, Их Британийн Белфастын хатан хааны их сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцогч талуудын саналыг тусгах замаар төгсөгчдийн эзэмших шаардлагатай мэдлэг ур чадварыг тодорхойлох, шинэчлэх
- Хөтөлбөрийн элсэлтийн хяналтын тоог ажлын байрны хэрэгцээ шаардлагуудтай уялдуулах, ажил эрхлэлт болон ажлын байран дээрхи өсөлт хөгжилтийг судлах,
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ зөвхөн топ 500 сургууль гэхээс илүү Монгол орны газар ашиглалт, болон хэв шинжийн хувьд ижил төстэй орнуудын сургалтын хөтөлбөр, онцлогыг харгалзах, ажлын байрны шаардлага, ажил олгогч нарын хэрэгцээ санал хүсэлтийг тусгах,

Зөвлөмж:

1. Ажил олгогчид, төгсөгчид болон үндсэн мэргэжлийн багш нарын саналыг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах,
2. Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж эргэх холбоог сайжруулах

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь 2014 оноос эхлэн либерал арт уламжлалд суурилсан сургалтын системд шилжсэн.
- Хөтөлбөрийн цахим засаглалыг амжилттай хэрэгжүүлж СиСи системээр багш оюутны сургалтын үйл ажиллагаа, үнэлгээ шинжилгээг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын аргазүй, хүрэх үр дүн, онцлог өөрийн үнэлгээний тайланд тодорхой тусгагдаагүй.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг холбогдох бүлэгт тусгаагүй. Сургууль дээр ажиллах явцад хичээлүүдээр эзэмших ур чадвараар мэргэжилтний эзэмших мэдлэг, ур чадвар тодорхойлогдсон болно.
- Ажил олгогчидтой хийсэн уулзалтын явцад бэлтгэн гаргасан мэргэжилтний онолын мэдлэг шаардлага хангаж байгаа боловч үйлдвэрлэлд ажиллах дадал ур чадвар хангалтгүй байгааг дурдаж байсан.

Зөвлөмж:

1. Газрын харилцааны салбар нь техник технологийн хөгжилтэй уялдан үйлдвэрлэлд хэмжилт зураглал болон газрын төлөв байдлыг тодорхойлогч орчин үеийн багаж тоног төхөөрөмж ихээр нэвтэрч байна. Мөн суурь мэдээллийн сан бүрдүүлэх болон боловсруулалт хийдэг орчин үеийн өндөр хүчин чадал бүхий программ хангамжууд нэвтэрч байгаа тул салбарын хөгжилтэй уялдуулан хөтөлбөрийн зорилго, төгсөгчдийн эзэмших ур чадвар, дадалд анхаарах шаардлагатай.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн төлөвлөлт сайн. МУИС болон Бүрэлдэхүүн сургуулиуд 2016-2024 оны стратеги төлөвлөгөөтэй. Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилладаг.
- Хичээлийн хөтөлбөр бүрт олгох мэдлэг, ур чадвар, дадлыг тусгаж өгсөн. Бүх хичээлийн хөтөлбөр нь нэг стандартаар боловсруулагдан холбогдох хороодоор орж албажсан. Сургалтын үнэлгээнд цахим үнэлгээний системийг нэвтрүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн үндэсний стандартыг хөтөлбөрийн төлөвлөлт, ур чадварыг тодорхойлохдоо харгалзан үзэх, дүн шинжилгээ хийх,
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж элсэлтийн болон төгсөлтийн бодлоготой уялдуулах,

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн гүйцэтгэлийн үр дүнд тэнхимийн хяналт оролцоо сул, холбогдох албадуудтай уялдаа муу байгаад анхаарч, мэргэжлийн тэнхимийн оролцоо, эрх үүргийг нэмэгдүүлэх,
2. Оролцогч сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, ажил олгогч талын хэрэгцээ, саналыг сайтар судлан, хичээлийн хөтөлбөр стандартуудын олгох мэдлэг, ур чадвар, дадлуудтай уялдуулан оруулдаг байх,
3. Хөтөлбөрийн хүрээнд холбогдох боловсролын төрийн байгууллага болон төв сургуулиас тогтоосон заавал орох хичээлийн эзлэх хувь ихэссэнээс мэргэжилтний заавал эзэмших хичээл орхигдож байгаа эсэх болон хичээлийн зохистой харьцаанд дүн шинжилгээ хийх,

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

МУИС ШУС-ийн БУС, Газарзүйн тэнхим нь дээрхи зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

1. Багш, оюутны ажиллах, сурах таатай орчин нөхцөлийг сайжруулах
2. Мэдээллийн сан, технологийн дэд бүтцийг хөгжүүлэх, компьютер, интернэт ашиглах боломжийг өргөтгөх

3. Сургалт судалгааны нээлттэй лабораториуд шинээр байгуулах
4. Сургалт, эрдэм шинжилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг зорилтыг тавин ажилласан бөгөөд энэхүү зорилтын хүрээнд сургалтын орчин нөхцөл хангалттай сайн бүрдсэн байна.

Онцлог зүйл/Туршлага.

Тэнхимийн нийт багш нар орчин үеийн техник технологи, интернэтийн сүлжээгээр бүрэн тоноглогдсон тохилог орчинд сургалт, судалгааны үйл ажиллагаагаа эрхэлж байна. Хичээлийн байрны засвар үйлчилгээг жил бүр тогтмол хийж, багш, оюутнуудын ширээ сандал, бусад тавилга, тоног хэрэгсэл худалдан авах зэрэг багш, оюутны сурч, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг жилээс жилд нэмэгдүүлж байна.

Газарзүйн тэнхим нь сургалтын орчин нөхцөл сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- 2008 онд “МУИС” Хөгжлийн сангийн 57.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурин дифференциал GPS, Total Station багажуудаар бүрэн тоноглогдсон компьютерийн орчин үеийн лабораторийг шинээр байгуулж ашиглалтад орууллаа. 2009 онд МУИС-ийн Хөгжлийн сангийн 12.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, тендер журмын дагуу 21.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан.
- 2009 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн шугамаар “Цөлжилтийг бууруулах, Газрын тогтвортой менежмент” төслийн санхүүжилтээр 14 сая төгрөгөөр HUATSAI Trimble R3 маркийн 1 долгионы суурин GPS авсан. 2012-2013 оны хичээлийн жилд тус тэнхимийн багш дэд проф. Б.Болормаагийн санаачилгаар хичээлийн 7 байрны 300 тоот ангийг Газар зохион байгуулалт болон кадастрын зураглалын кабинет болгон тохижуулсан.
- 2013-2014 оны хичээлийн жилд Нийслэлийн өмчийн харилцааны газраас зарлагдсан “Зуслангийн газрын өмчлөлийн бүртгэл” сэдэвт ажилд тэнхимийн багш оюутнууд оролцож санхүүжилт 14 сая төгрөгөөр 300 тоот ангийг проф Г.Пүрэвцэрэн багшийн нэрэмжит болгон, газар төлөвлөлт, кадастрын зураглалын лаборатори болгон тохижуулж байна.
- 2013 онд ГГС-ийн төсвийн хөрөнгөөс 75 сая төгрөгөөр 2 долгионы суурин PENTAX G3100 маркийн дифференциал GPS 1 ком, PENTAX R-422N маркийн Электрон тахеометр–2 ком, KOLIDA фирмийн электрон теодолит 10 ком, KOLIDA фирмийн электрон ниведир 10 комыг худалдан авалт хийснээр сургалтын материаллаг бааз ихээхэн хэмжээгээр бэхжсэн байна.

Анхаарах асуудал:

- Газарзүйн тэнхим нь 2011 оноос 2017-2018 оны хичээлийн жил хүртэл 3 удаа нүүдэллэсэн байна. Олон удаа нүүдэллэх нь хөтөлбөрийн тогтвортой хөгжил болон материаллаг баазыг бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. МУИС-ийн хичээлийн 2 байранд нүүж ирсэнээр анги танхимийн хүрэлцээ болон багш нарын ажиллах орчин төдийлөн хангалтай сайн биш байна.
- Оюутан бие даан болон багаар ажиллах орчин хангалтай бус бөгөөд хичээлийн бус цагаар мэргэжлийн лабораторит сууж бие даан суралцах нөхцөл боломж байхгүй байгаад анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

1. Багш нар бүх түвшний оюутныг хүлээн авч заавар зөвлөгөө өгч байх, бусад багш нарт саад болохооргүй тусгай өрөө танхимыг цаашид шинээр бий болгох шаардлагатай.

- Газар зохион байгуулалтын хөтөлбөрт ордог зарим нэг багаж тоног төхөөрөмжийг шинээр худалдан авах шаардлагатай байна. Үүнд: 2 долгионы GPS болон лабароторийн суурин компьютеруудыг шинэчлэх гэх мэт.
- Оюутны хичээлийн бус цагаар мэргэжлийн лабораторид сууж, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

- МУИС, ШУС, БУС-ийн Газарзүйн тэнхимийн нийт багшийн 60 хувь нь тус бүр иж бүрэн компьютертэй, орчин техник технологиор хангагдсан бол бусад багш нар өөрсдийн хувийн компьютерийг ашиглан ажиллаж байна.
- Багш нар Internet дотоод сүлжээг ашигладаг бөгөөд эдгээр нь хичээлийн байрны хооронд, өөр тэнхимийн багш нарын хооронд болон бусад нэгжүүдтэй шууд холбогдож мэдээлэл солилцох, файл шилжүүлэх зэрэгт чухал үүрэгтэй байна. Интернетийн хурдны хувьд төдийлөн хангалтай сайн биш юм. Хичээлийн материалаг нөөц, хэвлэмэл үзүүлэн болон тараах материалыг ашиглан хичээлийг заадаг. Багш нар өөрийн хичээлийн гарын авлага болон бие даалтын удирдамж, зөвлөмжийг цаг тухай бүрт оюутнуудад өгдөг.
- Хээрийн болон үйлдвэрийн дадлага удирдаж буй багш нарын хувьд удирдамж аргагүйгээр тогтмол хангадаг нь шинжээчдийн баг ажиллах үед ажиглагдсан.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн ШУС-ийн Газарзүйн тэнхимийн Газар зохион байгуулалтын мэргэжлийн 1-3 ангийн хээрийн дадлагуудыг зуны амралтаар 7-21 хоногийн хугацаатай Өвөр Зайсанд сургалт, судалгааны баазад явагддаг.
- Үйлдвэрлэлийн дадлагыг хичээлийн шинэ жил эхэлсэнээс хойш 5 долоо хоногийн хугацаатайгаар мэргэжлийн багш нарын заавар зөвлөгөө, удирдамжийн дагуу мөн дадлагад гарч байгаа албан байгууллагын мэргэжилтнүүдийн шууд удирдлаган доор жил бүр дадлага хийж гүйцэтгэдэг. Эдгээр дадлагыг хийж гүйцэтгэснээр оюутнуудын практик ур чадварыг нэмэгдүүлэх чухал ажил болдог.
- Газар зохион байгуулалтын мэргэжлийн заавал эзэмших ур чадварын нэлээд хэсгийг практикийн хичээл болон үйлдвэрлэлийн дадлагын явцад л олж авдаг. Ийм учраас дадлагын ажилд ихээхэн ач холбогдол өгч суралцах хугацаандаа өдрийн ангийн оюутан хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж нийтдээ 8 кредит авч байна.
- Сургалтын хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн мэдлэгийг бататгаж, ур чадвар эзэмшүүлэхэд “Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар”, “Нийслэлийн өмчийн харилцааны газар (Нийслэлийн газрын алба)”, Аймгуудын “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар”, Дүүргүүдийн “Газрын алба”, Боомт хотуудын захиргаа, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, уул уурхайн томоохон компаниуд болон салбарын үйлдвэрлэл үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий компаниудыг түшиглэн ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг худалдан авах
- Зарим нэг мэргэжлийн хичээл ордог программ хангамжийг лицензтэй болгох

Зөвлөмж:

1. Хээрийн болон үйлдвэрлэлийн дадлагууд нь батлагдсан удирдамжийн дагуу хийгддэг боловч дадлагын явцыг ажиглахад Геодезийн хээрийн дадлагын хувьд дадлага гүйцэтгэх хугацаа нь бага байна. Цаашид дадлага гүйцэтгэх хугацааг уртасгах хэрэгтэй.
2. Сургалтын хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх, боловсронгуй болгох нэг арга зам нь давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалт гэж үзэж БХБЯ болон ГЗБГЗЗГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулах.
3. Хөтөлбөр нь нэг талаас шинжлэх ухааны чиглэлтэй байх нь зүйн хэрэг ба нөгөө талаас газрын харилцааны ажил олгогч байгууллагуудын хэрэгцээг хангахуйц түвшинтэй мэргэжилтэн бэлтгэхдээ мэргэшлийн чиглэлүүдэд ажил олгогчдын сонирхлыг тусгах ажил нь шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

МУИС-ийн төв номын санд үндсэн сурах бичгүүд байгаа нь багш суралцагчдад хүртээмжтэй байдаг ба энэ нь хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйд бүрэн нийцдэг. Үндсэн сурах бичгээс гадна нэмэлт сурах бичгүүд хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйд нийцэж чаддаг.

Сургалт, судалгаанд багш, оюутнууд ашиглах лицензтэй программ хангамж байхгүй, мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлд зарим нэг Crack-н Tools нь ажилдаггүй нь судалгаа шинжилгээний ажилд цаг хугацааны хувьд хүндрэл учруулдаг бөгөөд цаашдаа мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдэд лицензтэй программ хангамж авч ашиглах шаардлага нэн тэргүүнд тулгараад байна.

Цахим орчны хүртээмж хангалттай боловч интернетийн хурд удаан гэдэг санал оюутнуудаас ирж байсан.

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн номын сан олон улсын номын сангийн автоматжуулалтын цогц систем болох Коха програм хангамжийг нэвтрүүлсэн байна.
- Олон улсын стандарт бүхий шинэ номын санг барьж ашиглалтад оруулсан.
- МУИС-ийн номын сангийн вэб сайтыг орчин үеийн технологийн дагуу уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц болгон шинэчлэн хийсэн байна. Уг вэб сайт нь агуулгын хувьд үндсэн болон дэд цэстэй, номын сангийн салбар уншлагын танхимуудын танилцуулга болон ОБДСТ-үүдийн мэдээллийг багтаасан, шинэ номын болон бусад мэдээ мэдээллийг харуулах нүүр хуудас, номын сангийн дүрэм журам, гадаад дотоодын онлайн сан, Монгол улсын нийтийн болон их дээд сургуулийн номын сангуудын холбогдох веб хуудасны холбоос, шинэ номын хүсэлт, санал

сэтгэгдэл, онлайн лавлагаа, оюутанд хэрэгцээтэй мэдээ мэдээллийн зарлалын хэсэг болон шилдэг уншигчдыг харуулах талбаруудтай болно.

Анхаарах асуудал:

- Номын санчид мэргэжлийн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллах.

.Зөвлөмж:

1. Нэмэлт гарын авлага, бусад материалууд нь хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйд нийцдэг боловч тоо хэмжээний хувьд нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх
2. Сургалтад лицензтэй программ хангамж ашиглах боломжийг нэмэгдүүлэх
3. Сургуулийн орчны интернетийн хурдыг нэмэгдүүлэх
4. Багш нарыг орчин үеийн компьютер тоног төхөөрөмжөөр бүрэн хангах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хөтөлбөрийн хороонд Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл, МУИС-ийн үндсэн багш, сургалт эрхэлсэн захиргааны ажилтан, ажил олгогчид, төгсөгчдийн төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэй байна.
- МУИС-ийн хөтөлбөрийн хорооны шинэчилсэн журам (2016.12.28)-ын хүрээнд хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт болон үйл ажиллагаа хэрэгждэг. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтыг хангахад шаардлагатай дүрэм, журмууд гарсан байна. Эдгээр бичиг баримтуудын хүрээнд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг шинэчлэн мөрдөж байна.
- МУИС-ийн 2016-2024 он хүртэлх хөгжлийн шинэчилсэн стратеги төлөвлөгөө, дунд болон богино хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхний хуралдаанаар батлан цаашид улирлаар ажлын гүйцэтгэлийг дүгнэн хэлэлцдэг байна. Жил бүрийн 11-р сард дараагийн санхүүгийн жилд төлөвлөгдсөн ажилд зарцуулах зардлыг урьдчилан тооцоолдог байна. Хичээлийн жилийн эцэст нийт багш нар “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу сургалт, эрдэм шинжилгээ, бусад ажил (сургууль, нийгэм, олон нийтэд хандсан үйл ажиллагаа) гэсэн үндсэн 3 чиглэлээр гүйцэтгэсэн ажлын тайлан бичиж, танилцуулдаг байна.

- СиСи системийн тусламжтай олон нийтийн оролцоог хангах боломж бүрдсэн байна. СиСи системд оюутнууд багш болон сургалтын орчны талаар “Сэтгэл ханамжийн судалгаа” улирал бүр тогтмол өгдөг байна.
- “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-д заасан тавигдах шаардлагыг хангасан хөтөлбөрийн багшлах боловсон хүчний үндсэн шалгуур болгодог. Багш нарын сургах заах аргагүйн чадварыг дээшлүүлэхийн тулд тус тэнхимд заах арга зүйн зөвлөл ажилладаг байна. Заах аргагүйн зөвлөл нь үзүүлэх болон нээлттэй хичээл зохион байгуулах, зөвлөгөө өгөх, туршлага судлах чиглэлээр багш нар харилцан хичээлд суух, сургалт семинарт хамруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байна.
- СиСи системийг МУИС-ийн салбар сургуулиудын багш, ажилтан, оюутан болон удирдлагууд ашигладаг. Энэ систем нь МУИС-ийн хүрээнд хэрэглэгддэг дэд системүүд болон гадны системүүдтэй хамтарч ажилладаг.

Анхаарах асуудал:

- СиСи системд оюутнууд багш болон сургалтын орчны талаар “Сэтгэл ханамжийн судалгаа”-г бөглүүлдэг боловч оюутны хамрагдалтын хувь хангалтгүй байгааг анхаарах.

Зөвлөмж:

1. СиСи системд оюутнуудаас авдаг судалгааны асуултыг илүү тодорхой нээлттэй байдлаар бий болгох, оюутны хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, тухайн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг хамруулах талаар багш нар ажиллах.

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Газар зохион байгуулалтын хөтөлбөртэй уялдсан салбарын, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа нарийвчлан хийгээгүй боловч салбарын хүний нөөцийн багтаамжийг төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тоо, мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий компаниудын тоо, хүний нөөцийн багтаамж зэрэг дээр үндэслэн баримжаа байдлаар таамаглал гаргасан байна. Мөн хөтөлбөрийн зүгээс Хөдөлмөр нийгмийн хамгааллын институт болон ХНХЯ-аас жил бүр эрхлэн гаргадаг “Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа” суурь мэдээлэл болгон ашигласан байна.
- МУИС-ийн суралцагч нь МУИС-ийн дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой. МУИС-ийг төгсөөд салбартаа амжилттай ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг оролцуулсан “Мэргэжил сурталчлах” өдөрлөгийг зохион байгуулдаг. Их, дээд сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулдаг олон төрлийн

олимпиадуудад амжилттай оролцдог. Цахим хэлбэрээр www.num.edu.mn сайтаар дамжуулан сургууль, хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг идэвхитэй хийдэг.

- Хөтөлбөрийн багш нар мэргэжлийн чиг үүргийн төрийн захиргааны байгууллагад сургалт, семинар зохион байгуулах зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлдэг байна.

Анхаарах асуудал:

- Цаашид хөтөлбөрийн зүгээс авч хэрэгжүүлж буй эдгээр ажлуудаа тогтмол тасралтгүй авч хэрэгжүүлэх, улам төгөлдөржүүлэн сайжруулах нь чухал хэдий ч хөтөлбөрийн хувьд санхүүгийн хараат, нөөцийн харьцангуй хязгаарлагдмал байдал нь энэ үйл ажиллагааг илүү далайцтай олон талыг хамарсан байдлаар авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болох талтай байна.

Зөвлөмж:

1. Газар зохион байгуулалтын хөтөлбөртэй уялдсан салбарын хөдөлмөрийн зах зээлийн судалгаа нарийвчлан хийж байх шаардлагатай.
2. Газрын харилцааны чиглэлийн мэдлэг чадвартай мэргэжлийн хүмүүс зайлшгүй ажиллах шаардлагатай ажлын байрны судалгаа хийж, оюутнуудад танилцуулах, мэргэших мэргэжлийн чиглэлээ тодорхойлоход тусалж байх;

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн нэгдсэн Facebook-ын <https://www.facebook.com/groups/numlandandurban/> “МУИС-ийн Газар зохион байгуулалт, Кадастр, Хот төлөвлөлтийнхөн” гэсэн группээр дамжуулан судалгаа авсан байна. Нийт төгсөгчдийн 58% нь мэргэжлийн салбартаа ажилладаг байна.
- МУИС-ийн сургалтын журмын 4.4.8, 4.4.9-д 3,2-оос дээш голчтой бакалаврын түвшний суралцагч магистрын хөтөлбөрийн зарим хичээлийг, 3,0-ээс дээш голчтой магистрийн түвшний суралцагч докторын хөтөлбөрийн зарим хичээлийг давхар судлах боломжтой. Төгсөгчдийн 15% магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж байна.
- Тэнхимийн зүгээс давтан сургалтыг богино хугацаатай захиалгат хэлбэрээр зохион байгуулж байна. Хамтран ажилладаг байгуулын хамтын гэрээний дагуу хийдэг байна. Нийслэлийн газрын албатай хамтран богино хугацаатай сургалыг зохион байгуулж хэвшсэн байна. (<http://gazar.ub.gov.mn/index.php/all-news/latest-news/311-2017-01-12-03-06-18>) 2017 онд МУИС, ГЗБГЗЗГ хооронд хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд салбарын мэргэжилтэн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх талаар хамтран ажилладаг байна. (<http://www.gazar.gov.mn/?p=810&n=1830>)
- Төгсөгчдийн холбоо байгуулсан бөгөөд албан ёсны группээр дамжуулан тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг байна.

- МУИС-ийн сургалтын журмын 4.4.8, 4.4.9-д 3,2-оос дээш голчтой бакалаврын түвшиний суралцагч магистрын хөтөлбөрийн зарим хичээлийг, 3,0-ээс дээш голчтой магистрийн түвшний суралцагч докторын хөтөлбөрийн зарим хичээлийг давхар судлах боломжтой.

Анхаарах асуудал:

- Давтан сургалтад хамрагдсан байдлыг албажуулж нэгтгэсэн мэдээллийн сан хараахан бүрдүүлээгүй байна.

Зөвлөмж:

1. Олон улсын болон улсын салбарын хэмжээнд газар зохион байгуулалт, кадастрын систем, геодези, агаар, сансрын зураглал, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр нэвтэрч байгаа шинэ техник, технологи, нэвтэрч байгаа байгаа шинэ системийн талаар давтан сургалтыг зохион байгуулах боломжтой юм. Шаталсан байдлаар хөтөлбөр төлөвлөгөөг Газрын харилцааны салбарын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжтой юм.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Шилдэг

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хамтын ажиллагаатай байдаг дэлхийн 120 их дээд сургуулиудын хамтын ажиллагааны гэрээний болон ОУ-ын байгууллагуудын хамтарсан санамж бичгийн хүрээнд оюутан солилцоо, багш солилцооны хөтөлбөрт тус хөтөлбөрийн багш оюутнууд хамрагдан олон улсын сургалт, семинарт оролцож, зохион байгуулдаг байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны хөх хотын БИС, Нидерландын ИТС, БНСУ-ын Сөүлийн Үндэсний их сургууль, Швед улсын Явлегийн их сургууль, эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээр, ӨМӨЗО-ны Хот төлөвлөлтийн товчоо, Хот төлөвлөлтийн хүрээлэнтэй эрдэм эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллаж байна.
- МУИС болон хөтөлбөр хариуцсан салбар нэгж нь хамтын ажиллагааны хүрээнд тус хөтөлбөрийн 3 багш ХБНГУ-ын Мюнхений ТИС, Япон улсын Гифу ИС, Швед улсын Явлегийн ИС зэрэгт магистрын хөтөлбөрт хамрагдсан байна. БНСУ-ын Сөүлийн ИС-ийн докторын хөтөлбөрт 1 багш суралцаж байна. ӨМӨЗО-ны БИС-ийн Газарзүйн их сургуультай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу ӨМӨЗО-ны Хот төлөвлөлтийн товчоо, Хот төлөвлөлтийн хүрээлэнтэй хамтран ажиллаж, 2012-оноос хамтарсан дадлагын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хамтарсан дадлагыг нийт харилцан солилцож Монгол болон ӨМӨЗО-д гүйцэтгэдэг. 2016 онд ГЗБ-ын 35 оюутан 3 багш ӨМӨЗО-ны Хөх хот-Ордос хот-Бугат хот маршрутаар хийсэн байна. ӨМӨЗО-ны БИС-ийн Газарзүйн сургуулийн 31 оюутан 3 багш ГЗБ-ын хөтөлбөрийн 2 багшийн хамт Улаанбаатар-Дархан-Эрдэнэт-Багануур-Улаанбаатар маршрутаар хээрийн дадлага гүйцэтгэсэн байна.
- Олон улс, Монгол улсын болон салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлгийг байнга тогтмол зохион байгуулдаг байна. Тухайлбал: ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбар ӨМӨЗО-ны БИС, БНХАУ-ын Газарзүйн ШУ, Байгалийн

нөөцийн Судалгааны хүрээлэн, Оросын газарзүйн Нийгэмлэгийн Буриадын салбар, Монголын ШУА, Газарзүй Геоэкологийн хүрээлэнтэй хамтран “Монголын тэгш өндөрлөгийн байгалийн нөөц, тогтвортой хөгжил” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг 11 жилдээ буюу тогтмол зохион байгуулдаг байна. Мөн Хөх хот ба Улаанбаатар хотын хот төлөвлөлтийн харьцуулсан бүрэлдэхүүн судалгааг ӨМӨЗО-ны БИС-ийн Хот төлөвлөлтийн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэсэн байна.

- “Монголын тэгш өндөрлөгийн байгалийн нөөц, тогтвортой хөгжил” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг 11 жилдээ тогтмол зохион байгуулдаг бөгөөд судалгааны ажилдаа бакалавр болон магистр оюутнуудыг хамруулж эрдэм шинжилгээний ажлыг дадлага практик эзэмшүүлдэг байна.

Зөвлөмж:

1. Эрдэм шинжилгээ судалгааны ажлуудын үр дүнгээ олон нийтэд сурталчлах, их дээд сургуулийн ижил мэргэжлийн тэнхим салбаруудтай хамтран ажиллах боломжтой юм.
2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилдаа багш нараа жигд татан оролцуулах, оюутны оролцоог нэмэгдүүлэх боломжтой.

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОУ-ын болон хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын үр дүнгээр хэлэлцүүлэг, семинар, уулзалтыг цаг тухай бүрд нь зохион байгуулж Газрын харилцааны салбарын мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудтай санал солилцож байдаг байна.
- ГЗБ-ын хөтөлбөр нь дотоод хамтын ажиллагааны хүрээнд ижил мэргэжлээр сургалт явуулдаг ШУТИС, ХААИС, Газрын харилцааны салбарын мэргэжлийн байгууллагууд, ГХ-ны салбарын төрийн бус байгууллагууд зэрэг төр, олон нийтийн байгууллагуудтай сургалт, үйлдвэрлэлийн дадлага, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр хамтран ажилладаг байна. Хөтөлбөрийн зүгээс салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулдаг байна. ГЗБ-ын хөтөлбөрийн багш нар ЭШХ-уудад оролцохоос гадна Улсын хэмжээний ЭШХ-ын шүүгч, зохион байгуулагчаар тогтмол ажилладаг байна.
- “Нийслэлийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний тодотгол” ажилд туслан гүйцэтгэгчээр тэнхимийн бүх багш оролцож ГЗБ, төлөвлөлтийн инженерийн иж бүрэн төсөлийн тайлан боловсруулж НИТХ-аар хэлэлцүүлж батлуулан, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.
- Хамтарсан эрдэм шинжилгээ судалгааны ажлуудын үр дүнг эмхэтгэн ЭШ-ний бүтээлүүд хэвлүүлж сургалтын үйл ажиллагаанд зориулан Улсын төв номын сан болон МУИС, салбар сургуулийн номын сангуудад үнэгүй байршуулах ажлуудыг хийсэн байна. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр санхүүжилтээр хэрэгжсэн “Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент” төслийн тэтгэлгээр “Газрын тогтвортой менежмент” хичээлийн сургалтад хэрэглэгдэх сургалтын төлөвлөгөө боловсруулсан.

Энэ хөтөлбөрийн санхүүжилтээр ГЗБ-ын хөтөлбөрийн сургалтад зориулж 7 800 000 төгрөгний үнэ бүхий дифференциал GPS багаж авсан байна. “Хөрсний доройтлын эсрэг арга хэмжээ, менежмент” сурах бичгийн орчуулгын ажилд хамтран оролцож зарим бүлгийн редактораар ажиллан, хэвлүүлсэн бүтээлээс 300 ширхэгийг Улсын төв номын сан, Экологийн боловсролын төв, МУИС-ийн номын сан зэрэгт хандивласан байна.

- ГЗБ-ын хөтөлбөрийн эрхлэгч, багш, д-р П.Мягмарцэрэн нь ГХГЗЗГ-ын 2014/101 тоот тушаалаар “Газрын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл” боловсруулах ажилд оролцож ажилласан байна.
- ГЗБ-ын хөтөлбөрийн багш нар ОУ-ын болон хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын үр дүнгээр хэлэлцүүлэг, семинар, уулзалтыг цаг тухай бүрд нь зохион байгуулж Газрын харилцааны салбарын мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагуудтай санал солилцож байдаг байна.

Зөвлөмж:

1. Хамтын ажиллагаанд багш нараа жигд татан оролцуулах, оюутны оролцоог нэмэгдүүлэх боломжтой.

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь төрийн өмч дээр суурилан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлаа өөрийгээ санхүүжүүлэх зарчмаар нөхдөг төрийн өмчийн сургууль юм. 2014-2015 оны хичээлийн жилээс МУИС-ийн хэмжээнд төсвийн төлөвлөлт, орлого хуваарилалт, бүтээгдэхүүний өртөг тооцооллын шинэ журамд шилжин ажиллаж байна. Цалин болон нэмэгдэл цалинг багшийн цагийн ачаалал дээр тулгуурлан багшийн зэргээр цалинжуулдаг. Шаардлагатай нэмэгдэл цалинг тооцож өгдөг. Мөн илүү цагийн ноогдол хөлсийг гүйцэтгэлээр олгодог байна.
- Газарзүйн тэнхимийн материаллаг баазыг бэхжүүлэх, суралцах орчныг бүрдүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг жил бүр тогтмол зарцуулдаг байна. Үүнд сургалтын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ном гарын авлага авахад 2014-2015 онуудад 28,5 сая төгрөг зарцуулсан байна.
- Төрийн болон хувийн хэвшлийн дэмжлэг, түүний зарцуулалтыг нарийвчлан харах боломжгүй байна. МУИС-ийн нийт орлого зарлагын ерөнхий тэнцэлээс харахад зарлага нь орлогынхоо 80%-тай дүйцдэг байна. Тэнхим төсвийн тооцоогоо төлөвлөхдөө тухайн хичээлийн жилд оюутан болон багшийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлууд, өмнөх хичээлийн жилд зарцуулсан зарцуулалтын дундаж, тухайн жилд дэвшигдэж буй зорилготой уялдуулан боловсруулж сургуулийн нийт төсөвт саналаа өгдөг байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч өөрийн сургалтын баазыг бэхжүүлэх хичээлийн болон багш нарын өрөөг тохижуулах, компьютер техник хэрэгслийн хангамжийг сайжруулахад зориулж сургуулийн төсөвт зардлаа тусгахаас гадна төгсөгчид болон

хамтран ажилладаг байгууллагуудтай төсөл гэрээт ажлыг гүйцэтгэж, гүйцэтгэлийн тодорхой хувийг сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн санхүүжилт бий болгодог. Сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн хандив тусламж авах, хамтран ажиллах эх үүсвэрээр бий болж буй хандив тусламж нь биет хэлбэрээр сургалтын орчныг тохижуулахад чиглэсэн байна.

Анхаарах асуудал:

- Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн хэмжээнд хөтөлбөрийн нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог гаргах шаардлагатай байна.
- Газарзүйн тэнхимийн цалингийн төсөв болон жилийн орлого, зарлагын тэнцэлийг сургалтын төлбөр дээр үндэслэн гаргасан байна. Эндээс харахад тус хөтөлбөр нь зардалаа нөхөөд 74 сая төгрөгийн нэмэх зөрүүтэйгээр сургалтын үйл ажиллагаа явагддаг байна. Газар зохион байгуулалтын хөтөлбөрөөр суралцагч нэг оюутны зардлыг тодорхойлоогүй байна.

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөвийг хамт олноороо хэлэлцэж батлах,
2. Хөтөлбөрийн хэмжээнд хийгдэх шинэчлэлт өөрчлөлтийн нарийвчилсан төлөвлөгөөтэй болох, хэрэгжих хугацаа, хүрэх үр дүнгээ тусгах, түүнийгээ сургалтын хуанлитай уялдуулан гаргах боломжтой.
3. Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн хэмжээнд болон хөтөлбөрийн нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог гаргаж дүн шинжилгээ хийх шаардлагатай.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Шилдэг

Онцлог зүйл/Туршлага:

- “МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2017 онд оюутан элсүүлэх журам” 2017.05.26-А/139, Газар зохион байгуулалтын хөтөлбөрт элсүүлэх журам (хүснэгт 4.1.1), МУИС-ийн оюутан мэргэжлийн хөтөлбөрт шинээр элсэхэд 2016-2017 оны хичээлийн жилд элссэн “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ыг 2016.12.21-А/341 батлан гаргаж, хөтөлбөрөөр оюутан элсүүлэхдээ мөрдөж, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Газарзүйн тэнхимийн элсэн суралцагчаас элсэлтийн ерөнхий шалгалтад Газарзүйн хичээлийн суурь болгон дагалдах шалгалтыг сонголтод оруулж өгсөн байна.

- МУИС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд МУИС-ийн элсэгч бакалаврын оюутан 1-р курстээ дээд боловсролын суурь болох шинжлэх ухааны хичээлүүдийг судалдаг бөгөөд 2-р курст дэвшин суралцахдаа өөрийн эзэмшихийг хүссэн мэргэжлийнхээ хөтөлбөрийг сонгодог байна. Мэргэжлийн чиглэл, хөтөлбөрөө сонгоход БУС-ын 2-3-р курст элсэгчидээс хамгийн олон оюутан Газар зохион байгуулалтын хөтөлбөрөөр сурах санал өгсөн боловч элсэлтийн тооны хязгаартай тул хүсэлт гаргасан оюутны дүнгийн жагсаалтыг гаргаж тухайн хөтөлбөрөөр суралцах оюутныг баталгаажуулсан байна.
- ШУС болон ГЗБ-ын хөтөлбөрөөр элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо 606-631 байгаа элсэн суралцагчийн үнэлгээ нь дунджаас дээш чанарын үнэлгээтэй байна. 2014-2015, 2015-2016, 2016-2017 онуудыг хамруулсан байна. ШУС, БУС болон ГЗБ-ын хөтөлбөрөөр элссэн оюутны тоо 1638/592/46 (хүснэгт 4.1.1; зураг 4.1.4) байна.

ШУС-ийн СА 985 оюутан хамруулсан уулзалт хийсэн. 1650 гарын авлага тараасан. www.sas.num.edu.mn веб сайтад танилцуулга PPT байрлуулсан.(2016 оны 08.23, 24-нд, 2016 оны 09.02-нд)(2017 онд үргэлжүүлж хийсэн талаар асуух) МУИС, ШУС, СА, ОА сургуулийн болон оюутны зөвлөлийн танилцуулга, оюутны мэдээ 1, англи хэлээр гүнзгийрүүлэн суралцах хичээлийн тухай материалууд тараасан (2016 оны 08.25-29-нд). Зөвлөх багшийн ажил үүргийн тухай танилцуулга PPT-г www.sas.num.edu.mn веб сайтад байрлуулсан. МУИС-ийн ГЗБ-ын бакалаврын оюутанд зориулсан гарын авлага файл хэлбэрээр ШУС-ийн үүргийн тухай танилцуулга PPT-г www.sas.num.edu.mn веб сайтад байршуулсан.

Анхаарах асуудал:

- Газар зохион байгуулалтын хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд мэргэжлийн талаар хангалттай мэдээлэл авч орж ирээгүй байгаа оюутнуудтай уулзалт хийсэн ярилцлагаас харагдаж байлаа. Яаж энэ мэргэжлийг сонгосон талаар асуухад “нэр нь ШУС-ийн бусад мэргэжлүүдтэй харьцуулахад илүү сонирхол татсан учраас сонгосон” гэж ихэнх оюутан хариулсан.

Зөвлөмж:

1. МУИС-ийн ГЗБ-ын бакалавр оюутанд зориулсан гарын авлага файл хэлбэрээр ШУС-ийн үүргийн тухай танилцуулга PPT-г www.sas.num.edu.mn веб сайтад байрлуулсан нь ерөнхий мэдээлэл өгдөг байна. Мэргэжил сурталчлах өдөрлөгийг мэргэжил сонгох улирлын өмнөх улиралд хийж байх. Энэ үйл ажиллагааг тогтмол арга хэмжээ болгох, мэргэжлийн хамтарч хийх, мэргэжлийн байгуулагууд дээр танилцуулга хичээл явуулах.

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үрдүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн сургалтын албанаас зөвлөх, чиглүүлэх үйлчилгээний чиглэлээр хийх ажлуудын төлөвлөгөөг гаргадаг байна. Гарын авлагыг хичээлийн шинэ жилийн эхэнд болон сургалтын улирал бүр тараадаг. Гарын авлага, зөвлөмж хэвлэмэл болон цахим хэлбэрээр байдаг. Сургуулийн орчинд явагддаг оюутанд зориулсан төрөл бүрийн нийгмийн болон сургалтын арга хэмжээг зохион байгуулдаг.
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежерийн үйлчилгээний чанарын талаар судалгаа авсан байна. МУИС-ийн арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний талаар оруулсан байгаа боловч тодорхой мэдээлэл дутуу байна. МУИС-ийн оюутнуудад “Эмчилгээний кабинет”, “Сэтгэлзүйн оношлогоо, сургалт судалгааны төв, “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” зэрэг төвүүд ажилладаг байна.
- МУИС болон салбар сургуулийн хүрээнд ЦЕГ, НЭМГ, болон тодорхой сэдвүүдээр лекц, зөвлөгөөн зохион байгуулдаг гэсэн байна. “World”, “Geo-data”, “Land management” клубууд үйл ажиллагаа явуулан мэргэжил сурталчлах өдөрлөг, дадлага, экскурс хичээл зохион байгуулах, улсын болон оюутны олимпиад зохион байгуулдаг. Сургуулиас зохион байгуулдаг соёл хүмүүжлийн ажилд оюутнуудыг идэвхтэй татан оролцуулдаг. 2011 онд Улсын Драмын Эрдмийн театртэй МУИС-ийн гэрээний дагуу хямдралтай үнээр драмын жүжгүүд үзэх боломжтой болсон.
- “World”, “Geo-data”, “Land management” клубуудын үйл ажиллагаа болон оюутны зүгээс хийсэн сайн дурын үйл ажиллагааг хөтөлбөрийн багш нарын зүгээс маш сайн дэмжин ажилладаг бөгөөд янз бүрийн уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн байна. Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилт, түүний зарцуулалтыг Оюутны албаар дамжуулан хэлэлцэж, мөн тайлагнаж, үр дүнг үнэлдэг байна. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг бөгөөд цаг үеийн янз бүрийн ойн ажиллагааны талаарх мэдээллийг цахим хэлбэрээр байнга нийтэлж мэдээлж байдаг байна. (www.news.num.edu.mn)
- Хөтөлбөрийн багш нар өөрсдийн оролцож байгаа төсөл хөтөлбөр гэрээт ажилдаа оюутнуудыг тодорхой хэмжээгээр хамруулдаг байна. Хамтарсан төсөл, судалгааны ажлуудын үр дүнгээр улсын болон их сургуулийн, салбар сургуулийн, тэнхимийн эрдэм шинжилгээний хурал олимпиадад удирдан оролцуулдаг байна.
- Хөтөлбөрийн багш нар оюутныг эрдэм шинжилгээ судалгааны ажилдаа дагалдуулж дадлагажуулж ажиллахаас гадна улсын болон их сургуулийн, салбар сургуулийн, тэнхимийн эрдэм шинжилгээний хурал олимпиадад удирдан оролцуулж байнга амжилт үзүүлдэг байна.

Анхаарах асуудал:

- Зөвлөх багш, Сургалтын туслах ажилтан, сургалтын менежерийн үйлчилгээний чанарын талаар судалгаа авсан байна. МУИС-ийн арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний талаар оруулсан байгаа боловч тодорхой мэдээлэл дутуу байна. МУИС-ийн оюутнуудад “Эмчилгээний кабинет”, “Сэтгэлзүйн оношлогоо, сургалт судалгааны төв, “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв” зэрэг төвүүд ажилладаг байна. Эдгээр төвүүдийн үйл ажиллагаанд тус хөтөлбөрийн оюутнуудын хамрагдсан хувь хэмжээ бага байна.

Зөвлөмж:

1. МУИС-ийн СА-аас Зөвлөх, чиглүүлэх үйлчилгээний чиглэлээр хийх ажлуудын төлөвлөгөөг гаргадаг байна. Гарын авлагыг хичээлийн шинэ жилийн эхэнд болон сургалтын улирал бүр тараадаг. Гарын авлага, зөвлөмж хэвлэмэл болон цахим хэлбэрээр байдаг. Сургуулийн орчинд явагддаг оюутанд зориулсан төрөл бүрийн нийгмийн болон сургалтын арга хэмжээг зохион байгуулдаг. Гэвч тус хөтөлбөрийн

оюутнуудын хамрагдалтын хувь бага байна. Энэ талаар тэнхимийн багш нар анхаарал тавьж ажиллах шаардлагатай.

2. Сургуулийн сургалтын орчны үйлчилгээний байгууллагын талаарх “сэтгэл ханамж”-ийн судалгаанд 49% хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна. Хөтөлбөрийн багш нар энэ тал дээр анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдаг
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны алба, салбар сургуулийн оюутны холбоонд хөтөлбөрийн оюутнуудын сайн дурын клубууд харьяалагдан үйл ажиллагаа явуулдаг. Оюутны алба нь оюутан мэргэжилтнүүдтэй бөгөөд 8 чиглэлийн үйл ажиллагааг явуулдаг. Дээрх дэд шалгуурын хүрээнд МУИС-ийн оюутны албанаас сайн дурын ажил, нийгмийн үйлчилгээг (Social and volunteer services) ажилладаг. Салбар сургуулийн хэмжээнд явуулдаг урлаг, спортын арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийг салбар сургуулийн төсвөөс дэмждэг. “Land lord” клуб тэнхимийн багш нартай хамтарч экскурс хичээл зохион байгуулсан.
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтэд 47,7% нь дундаас доош үнэлгээ өгсөн байна. Зориулалтын дагуу зарцуулдаг байдалд дундаж оноог өгсөн байна. МУИС-ийн ШУС-ийн БУС-ийн оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд 10060090 төгрөгийг зарцуулсан байна. Жилийн нийт төсвийн 0,5-0,7% эзэлж байна. (www.news.num.edu.mn)
- Санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдалд 56,8% нь дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. МУИС-ийн Оюутны албаар дамжсан тэтгэлэг, тэтгэмжийн талаар МУИС-ийн вэб хуудасны шилэн дансаар тайлагнадаг.

Зөвлөмж:

1. Оюутны клуб болон оюутны байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд нийгмийн, олон нийтийн арга хэмжээг явуулах ажлын төлөвлөгөөг тэнхимийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах шаардлагатай. Тогтмол явуулах боломжтой үйл ажиллагаануудын хүрээнд зөвлөх үйлчилгээний удирдан чиглүүлэх, сургуулийн албан ёсны үйл ажиллагаанд бүртгүүлж, татан оролцуулах арга хэмжээ авах боломж бүрдэнэ.
2. Зөвлөн туслах үйл ажиллагааг зөвхөн зөвлөх багшийн үүргээр хязгаарлахгүйгээр тэнхимийн багш нарыг жигд хамруулах шаардлагатай. Хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, гүйцэтгэлд хяналт тавьж болох юм.

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд

- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь суралцагчдад урамшуулал, тэтгэлэг олгохдоо МУ-ын ЗГ-ын 2012.01.18-ны 19 тоот тогтоолын хавсралт 1, 2-ыг баримтлахаас гадна МУИС-ийн захирлын 2015.05.06-ны өдрийн А/126 тоот тушаал “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журам”-ыг батлан хэрэгжүүлдэг байна. Хөнгөлттэй зээл, Буцалтгүй тусламж, Урамшууллын тэтгэлэг авсан оюутны тооцоог гаргасан байна.
- Төгсөгчдийн сурлагын дүнгийн үнэлгээний голч, сурлагын амжилтыг сүүлийн 3 жилээр гаргасан байна. Оюутны урлаг, спорт, бусад амжилтууд жил ирэх тусам ахисан байна. МУИС-ийн суралцагчдад зориулсан МУ-ын хуулийн дагуу суралцагчдад олгох үндэсний ба урамшууллын тэтгэлэг, МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, МУИС-ийн ЭЗ-ийн нэрэмжит тэтгэлэг, Гадаад, дотоодын байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг, төгсөгчид, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлэг болон бусад тэтгэлэг хөтөлбөрүүд байдаг байна. Тэнхимийн хэмжээнд оюутан, суралцагсад хангалттай сайн хамрагддаг байна.
- МУИС-ийн захирлын 2015.05.06-ны өдрийн А/126 тоот тушаал “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журам” гарсан нь оюутан суралцагсдын суралцах идэвх, сурлагын амжилтад нөлөөлсөн байна.

Анхаарах асуудал:

- Дээрх тэтгэлэгүүдэд Оюутны албаар дамжуулан хамрагдах боломжтой ч одоогийн байдлаар тус хөтөлбөрийн оюутнууд хамрагдсан мэдээллийг салгаж гаргаагүй байна.

Зөвлөмж:

1. Газар зохион байгуулалтаар суралцаж байгаа оюутнуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан талаар судалгаа байхгүй байна.
2. Оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар мэдээлэл өгөх, тийм хүсэлтэй оюутануудыг дэмжин ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулж хэрэгжүүлэх. Багш нар жигд оролцох боломжтой юм.

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016.12.26-ны өдрийн А/348 тоот “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ын хүрээнд суралцагчийн судалсан багц цагийг дүйцүүлэн тооцож байна. Энэ харилцааг зохицуулах эрхзүйн баримт бичгийг үндэслэл болгон баримталдаг байна.
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой судалгаа хийж баримтыг хавсаргасан байна. Тус хөтөлбөрөөр суралцагчид өөр сургууль, хөтөлбөрийг сонгон шилжих шилжилт хөдөлгөөн байхгүй байна. Харин тус хөтөлбөрөөр суралцахаар өөр их, дээд сургууль болон салбар сургуулиас оюутнууд шилжин ирсэн байна.
- МУИС нь суралцагсдын шилжилт хөдөлгөөний дүрэм журмыг 3 удаа шинэчлэн сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд: МУИС-ийн захирлын 2012.12.7-ны 652 тоот тушаал “Оюутан шилжүүлэн суралцуулах журам”; 2015.12.24-ний А/375

тоот тушаал “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам”; 2016.12.26-ны А/348 тоот тушаал “Суралцагч шилжүүлэн суралцуулах журам” зэрэг болно. Уг журамд МУИС-д шилжин суралцахад шаардагдах гол шаардлага, үзүүлэлтийг тодорхой тусгасан байна. Мөн мэдээллийг СА-аас авахаас гадна цахим хэлбэрээр <http://shiljilt.num.edu.mn> сайтаас авах боломжтой.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. Холбогдох хууль тогтоомжид үндэслэн, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог байна. Журамд тусгагдсан тодорхой шалгууруудыг хангасан нэр дэвшигчийг шалгаруулалтаар ажилд авдаг. МУИС-ийн стратеги төлөвлөгөө /2016-2014 он/-нд зааснаар багшийн судалгааны ажлыг дэмжсэн зохион байгуулалт үнэлгээ урамшуулалын системийг бий болгож байна.
- Доктор зэрэгтэй багш 6 буюу газар зохион байгуулалтын хөтөлбөрийн нийт багш нарын 60%-ийг эзэлж байна.
- МУИС-ийн захирлын 2012.12.07-ны 652 тушаал МУИС-ийн багшийн ажлын нэгдсэн үнэлгээний (аттестатчиллын) журмыг баримталдаг байна. Уг журамд 15 оюутанд 1 багш байна гэж багш оюутны харьцааг тодорхойлж тусгасан байдаг. Тус хөтөлбөрийн багш оюутны харьцаа 2014-2015 онд 5,2:1 буюу 5 оюутанд 1 багш; 2015-2016 онд 3,2:11 буюу 3 оюутанд 1 багш; 2016-2017 онд 5,0:1 буюу 5 оюутанд 1 багш гэсэн харьцаатай байна.
- МУИС-д профессор багш ажиллуулах журмын 8-р зүйл, МУИС-ийн захирлын 2017.08.31-ны Б/363 дугаар тушаалын хавсралт “Профессор, багш нарын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний загвар шинэчлэн батлах тухай” журам зааврын дагуу ГЗБ-ын хөтөлбөрийн профессор багшийн зэрэглэл, ангиллыг тогтоон ажилладаг байна.

- Хичээлийн жилийн эцэст багш өөрийн үнэлгээний тайлангаар <http://research.num.edu.mn> цахим хуудсаар ажлын байрны тодорхойлолтыг хангаж байгаа байдалд үнэлгээ өгнө. Багшийн ажлын норм, кредит цагийн ноогдол, илүү цагийн гүйцэтгэлийн цалин хөлсийг хэрхэн тооцдог талаар тусгасан байна. 2016-2017 оны хичээлийн жилээс чанарын үнэлгээнд суурилсан урамшууллыг олгож эхэлсэн байна. Үүнд: Жилийн эцэст тогтсон шалгуурын дагуу багшийн болон удирдлагын үнэлгээ хийсэн байна.

Зөвлөмж:

1. Профессор багшийн зэрэглэл, ангилалд үндэслэн багш нарын ачаалалыг тодорхойлсон байна. Үнэлгээний үндсэн шалгуураас шалтгаалан Их сургуулийн үндсэн үйл ажиллагаа болох сургалтын үйл ажиллагааны зарим нэг хэсгүүд үнэлгээний ач холбогдол багатай болсон нь харагдаж байна. Сургалтын үйл ажиллагааг дэмжих, оюутны амжилтыг багшийн ажлын үнэлгээг нэмэгдүүлэх шалгуур болгох боломжтой.

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны аргазүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн БХТ-өөс зохион байгуулдаг судалгааны арга зүйн семинарт Газарзүйн хөтөлбөрийн багш нар идэвхтэй хамрагддаг байна. Багш нарыг гадаад дотоодын урт, богино хугацааны сургалтад явахад дэмжиж, янз бүрийн нөхцөлөөр хөнгөлөлт үзүүлэхээс гадна ажлын байрыг хадгалдаг. Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон нэг сэдэвт бүтээлийг гадаад дотоодын сонин сэтгүүлд хэвлэн нийтлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна.
- МУИС-ийн хэмжээнд Багшийн хөгжлийн төв 2016 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Багшийн хөгжилд анхааран тусгай нэгж байгуулан багшийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөөтэй ажиллаж байна. ГЗБ-ын хөтөлбөрийн Газар зохион байгуулалт, газар ашиглалтын төлөвлөлт, хот төлөвлөлт, газрын кадастр, геодезийн чиглэлийн мэргэшиж байгаа 2 багш МУИС-ийн докторант багшийн тэтгэлэгт хамрагдсан. Хөтөлбөрийн багш нарын эрдэм шинжилгээ судалгааны 4 ажил тэтгэлэг авсан байна.
- МУИС-ийн болон тэнхимийн зүгээс багш нарыг дадлагажуулах, тэдний сурган заах арга зүй багшлах ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Газар зохион байгуулалтын хөтөлбөрийн бүх багш нар Сурган заах аргазүйн сургалтад хамрагдаж сертификат авсан байна.
- Хөтөлбөрийн багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхи хангалттай сайн бүрдэж чадсан байна. Хөтөлбөрийн багш нар ОУ-ын мэргэжлийн сургалт, уулзалт семинар болон хамтарсан сургалт, төсөл, дадлагыг ХБНГУ, БНХАУ, БНСУ, Швед, ОХУ, ӨМӨЗО, Япон зэрэг орны мэргэжилтнүүдтэй хамтарч хийсэн байна.

- Хөтөлбөрийн багш нар ОУ-ын болон дотоодын салбарын чиглэлийн богино хугацааны сургалт семинарт хамрагдаж, газрын харилцааны салбарт шинээр нэвтэрч буй техник, технологи, түүний хэрэглээ, туршлагын талаар мэдлэг чадвараа байнга дээшлүүлж байна.

Зөвлөмж:

1. Газар зохион байгуулалтын хөтөлбөрт хичээл заадаг багш нарын мэргэжлийг дээшлүүлэх талаар тэнхимийн зүгээс хөтөлбөрийн багш нарын хамтын хэлэлцүүлгээр шаталсан хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх боломжтой.
2. Хөтөлбөрийн багш нарын хувь хүний хөгжил, сурган заах аргазүйн чадварыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, семинарын төлөвлөгөөтэй болгож хэрэгжүүлэх боломжтой.
3. Ижил хөтөлбөртэй Их дээд сургуулийн багш нартай туршлага солилцох, ахмад багш нараас туршлага судлах арга хэмжээндээ залуу багш нарыг байнга хамруулах боломжтой.

5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Шилдэг

Онцлог зүйл/Туршлага:

- ОУ-ын болон улсын хэмжээний төсөл хөтөлбөрт хамтран оролцож, тэдгээрийн судалгааны ажлын үр дүнгээр ЭШХ зохион байгуулж илтгэлүүдийн эмхтгэлийг гаргасан байна. НҮБ-ын санхүүжилтээр хийгдсэн номын орчуулгад тодорхой бүлгүүдийг орчуулах, редактораар ажиллах зэргээр ажиллаж хэвлэлтийн бүтээлүүдэд зохиогчийн эрхийг авсан байна.
- ГЗБГЗЗГ болон Нийслэлийн газрын албатай хамтран ажиллаж “Нийслэлийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний тодотгол” ажилд туслан гүйцэтгэгчээр тэнхимийн бүх багш оролцож ГЗБ, төлөвлөлтийн инженерийн иж бүрэн төслийн тайлан боловсруулж НИТХ-аар хэлэлцүүлж батлуулан, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.
- Эрдэм шинжилгээний судалгаа гэрээт ажил, бүтээл, төсөл хөтөлбөрүүдийг үр дүнгүүдээр нэг сэдэвт бүтээлүүдийг гаргаж сургалтын үйл ажиллагаанд гарын авлага, практик дасгалын ажилд эх материал болгон ашиглаж байна.
- ГЗБ-ын хөтөлбөрийн багш нарын үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд бүтээлийн судалгааг багш бүрээр гаргасан байна. Тус хөтөлбөрийн багш нар 32 төслийн ажил, 190 эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт 12, ном сурах бичиг 23, үйлдвэрлэлд 95, ГЗБ-ын мэргэжлийн чиглэлийн сэдэвчилсэн зураг 15-ыг гүйцэтгэсэн бөгөөд сургалтын материал болгон ашиглаж байна.
- ГЗБ-ын хөтөлбөрийн багш нарын ном, сурах бичиг, гарын авлага болон ГЗБ-ын мэргэжлийн чиглэлийн сэдэвчилсэн зураг, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг бусад Их дээд сургуулийн ижил хөтөлбөрөөр суралцдаг оюутнууд, мэргэжлийн байгууллагад ажиллаж буй мэргэжилтэн нар байнга ашигладаг байна.

Зөвлөмж:

1. Эрдэм шинжилгээ, судалгааны олон ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн боловч баталгаажуулаагүй, нэгдсэн файл үүсгээгүй байна. Гүйцэтгэсэн ажлын тайлан, хүлээлгэн өгсөн ажлуудын төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн талаар жагсаалт гаргаж, мэдээллийн сан үүсгэх боломжтой.
2. ОУ-ын болон Улсын хэмжээний төсөл хөтөлбөрт хамтран оролцож, тэдгээрийн судалгааны ажлын үр дүнгүүдийн талаар бүртгүүлэх, патент, зохиогчийн эрх авч баталгаажуулах боломжтой.

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар улирал бүр үйл ажиллагааны тайлан бичиж үнэлүүлдэг. Шинэ залуу багш нар өөрийн үнэлгээний тайлангаа бичиж сургуулийн сургалтын албанд дүгнүүлдэг. Багш бүр хичээлийн жилийн эцэст өөрийн үнэлгээний тайлан гаргаж хэлэлцүүлдэг байна.
- “МУИС-ийн багшийн ажлын нэгдсэн үнэлгээний (аттестатчиллын) журам”-ыг баримтлан хийдэг. Оюутны үнэлгээ, комиссын үнэлгээ, мэргэжлийн удирдлагын үнэлгээ гэсэн чиглэлээр хөндлөнгийн үнэлгээ хийдэг байна. Хөтөлбөрийн багш нар өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр хангалттай сайн үнэлэгдсэн байна.
- Хөтөлбөрийн онцлогоос хамаарч тухайн хөтөлбөрийн сургалтын тайлан бичиж хамгаалах зэргээр багаар ажиллах, бодит судалгаа хийх, тайлан бичиж хамгаалах зэргээр цогц байдлаар хэрэгждэг. Сургалтын үйл ажиллагааны туршид хэмжилтийн багаж хэрэгсэл ашиглан зураглал хийх, хэмжилтийн үр дүнг мэргэжлийн программын тусламжтай боловсруулах, төрөл бүрийн агуулга, масштабтай зураг үйлдэх зэрэг биет даалгавар гүйцэтгэж, тайлан бичиж хамгаалдаг. Хөтөлбөрийн багш нар сургалтын үйл ажиллагааг цогц байдлаар явуулж чаддаг байна.
- Улирал бүрийн эхэнд болон эцэст сургалтын үйл ажиллагаатай холбоотой санал асуулгыг багшийн заасан хичээл тус бүрээр оюутнаас нэгтгэн авч, дараа улирлын хичээлийн төлөвлөгөө, заах багшийг тогтоож түүнийхээ дагуу хичээл сонголтын хувилбар хэлбэрээр сургалтын төлөвлөгөө боловсруулдаг байна.
- Хөтөлбөрийн багш нар хичээл бүрийн агуулгад нийцсэн хичээлийн хөтөлбөрийг батлуулж сургалтад баримталдаг байна. Багш нар улирлын болон хичээлийн жилийн эхэнд төлөвлөгөө гаргадаг байна. Мөн улирлын, хичээлийн жилийн эцэст ажлын гүйцэтгэлээр тайлан тавьж хэлэлцүүлдэг байна. Төлөвлөгөө болон гүйцэтгэлээр ажлын үр дүнг хэлэлцэж биелэлтийн байдалд үнэлгээ өгдөг байна.
- Хөтөлбөрийн багш тус бүр дээр хувийн хэрэг нээж баримт материал бүрдүүлэлтийг хичээлийн жилийн эцэст гүйцэтгэлээр баяжуулан шинэчилдэг байна. Хөтөлбөрийн багш бүр сургалтын болон сургалтын бус үйл ажиллагааны талаар мэдээллээ баримтжуулан хувийн хэрэг, материалдаа нэмдэг байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ байгууллагын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд судалгаа хийж, үр дүнд түшиглэн мэргэжлийн судлах багц цагийг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Монголын газрын харилцааны салбар болон олон улсын газрын харилцааны салбарын хөгжил, чиг хандлага, техник технологийн шинэчлэлт, хөгжлийн дэвшилтэт байдал зэргийг харгалзан хөтөлбөрийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.
- Хөтөлбөрийн сургалтын агуулгыг сайжруулан шинэчилсэн байна. Сургалтын агуулгын хүрээнд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн уялдаа холбоог хангаж, хичээлүүдийн агуулгаар мэдлэгийг шаталсан байдлаар тухайн чиглэлээр гүнзгийрүүлэн судалж, тэр чиглэлээр цогц мэдлэг чадвар, дадал эзэмших боломжтой болгосон байна.
- www.sisi.num.edu.mn буюу СиСи системийн тусламжтай суралцагчид хичээл болон багшид санал өгч, цаашид сонголтоо баталгаажуулан суралцах боломжтой болсон. Энэ хүрээнд СиСи системд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг бүрэн байршуулсан бөгөөд тухайн хөтөлбөрийн суралцагчийн хувьд сургалтын хөтөлбөрийн дагуу заавал судлах хичээлүүдийг сонгон үзэхээс гадна сонгоны хичээлүүдийг судлан үзэх боломжтой. Цаашид мэргэших, илүү шинэ мэдлэг олж авахыг хүсвэл чөлөөт сонголтуудын хичээлээр өөрийн дуртай сонирхсон сургалтуудыг авах боломжийг бий болгосон байна. Улирлын эцэст оюутнаас хичээлийн явц, багшийн үйл ажиллагаа, аргазүйн талаар санал авч, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн хичээлийг ямар багшаар оруулах шийдвэрийг хэлэлцэж гаргадаг байна. Нэг хичээл дээр хэд хэдэн багшийг мэргэшүүлж, сонголтыг мөн тэдгээр багшийн хичээлийн хуваарьт тусгаж хийдэг байна.
- “МУИС-ийн сургалтын журам” баримтлан хөтөлбөрийн агуулгын хүрээнд онол, практикийн зохистой харьцааг бий болгож тусгасан байна. Тухайлбал: Лекц, лаборатори, бие даалтыг багц цагийн хүрээнд хуваарилаж өгөгдсөн объект дээр

биет байдлаар хэмжилт, бүртгэл судалгаа хийж, түүнийгээ программ хангамж ашиглан боловсруулж, тайлан төсөл хэлбэрээр бичиж хамгаалдаг байна.

- Хээрийн дадлага I - Геодезийн чиглэлээр, Хээрийн дадлага II - Газар төлөвлөлт, Хээрийн дадлага II - Газрын кадастрын бүртгэл, судалгаа гэсэн чиглэлүүдээр, мөн үйлдвэрлэлийн дадлага хийж гүйцэтгэдэг байна. МУИС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд дээд боловсролын суурийг нэгдсэн байдлаар 1-р курст судалдаг болсноос шалтгаалж зарим нэг мэргэжлийн суурь хичээлүүдийн дадлагын цагийг хассан байна.
- Цахим хэлбэрийн сургалтын арга зүйг нэвтрүүлээд эхэлсэн байна. Цахим хэлбэрийн сургалтад (СиСи, OCW, facebook, email, e-gazar.blogspot.com) платформуудыг ашиглан явуулж байна. СиСи системд 2 хичээлийн файлыг иж бүрнээр PDF хэлбэртэйгээр байршуулсан байна.
- Газар зохион байгуулалт хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн суурь болон мэргэжлийн заавал үзэх хичээлүүдийг судлахын өмнө дээд боловсролын суурь хичээлүүдээс гадна тухайн мэргэжлийн шаардлагад хэрэгцээтэй байгаль, орон зай, газарзүй, газарзүйн мэдээллийн систем зэргийн үндсийг тусгасан суурь ойлголт бүхий өмнөх холбоо байдлаар заавал судлахаар оруулсан байна. Мөн мэргэжлийн заавал судлах хичээлүүдийг мэргэжлийн онолын болон шинжлэх ухааны үндэстэй олгох үүднээс залгамж, уялдаа холбоог бий болгон хөтөлбөрийг боловсруулсан байна.

Анхаарах асуудал:

- ГЗБ-ын мэргэжлийн суурь мэдлэг болох хөрс судлал, ургамлын хичээлийн онолын болон дадлагын цагийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

1. Мэргэжлийн суурь хичээлүүдийн дадлагын цагийг хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд багасгаж, зарим хичээлийнх хасагдсан байна. Зайлшгүй эзэмших мэдлэг чадварыг бүрэн эзэмшүүлэх шаардлагатай хичээлүүдийн дадлагын цагийг нэмэгдүүлэх шаардлагатай.
2. Цахим хэлбэрийн сургалтын арга зүйг нэвтрүүлээд эхэлсэн боловч хөтөлбөрийн хэмжээнд СиСи системд 2 хичээлийн файлыг иж бүрнээр PDF хэлбэртэйгээр байршуулсан байгаа нь хангалтгүй байна. Мэргэжлийн хичээлүүдийг сонирхолтой байдлаар “е” хэлбэрээр бэлтгэж цахим байдлаар байршуулах боломжтой.
3. Хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан зайн сургалтыг зохион байгуулах боломжтой.
4. Давтан сургалтыг зайн хэлбэрээр суралцагчийн ажлын бус цагаар тодорхой хуваарьтайгаар хийх боломжтой.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын аргазүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам, зааврын дагуу баталсан маягт загвараар тухайн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн боловсруулсан байна. МУИС-ийн Сургалтын

нэгдсэн албанаас гаргасан сургалтын баримт бичиг боловсруулахад хэрэглэх стандарт, гарын авлагын дагуу гүйцэтгэсэн байна. 2014 онд Шинэчилсэн хөтөлбөрт багтсан бүх мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж “Газар зохион байгуулалт бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр” гарын авлагыг гаргаж сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хөтөлбөрийн бүх багш нар батлагдсан тодорхойлолт, хөтөлбөрийн зааврын дагуу сургалт явуулж байна.

- Хичээлүүдийн агуулга, онцлогоос хамааран янз бүрийн аргуудыг хослуулан ашигладаг байна. Лекцийн болон семинар, лабораторийн хичээлд ашиглаж байгаа арга зүй харилцан адилгүй байдаг байна. Сургалтын ямар арга зүй илүү оновчтой, хүртээмжтэй талаар суралцагчдаас санал асуулга авч үйл ажиллагаандаа тусгадаг байна.
- Мэргэжлийн хөтөлбөрийн онцлог давуу тал нь программ хангамж, багаж техник хэрэгсэл байдаг учраас сургалтад нийтлэг хэрэглэдэг хэрэгсэлээс гадна мэргэжлийн программ, багаж хэрэгсэл ашигладаг байна.
- Сургалт судалгааны аргазүйг байнга хөгжүүлдэг байдал ажиглагдаж байгаа боловч энэ нь тодорхой харагдахгүй байна. Улирал тутамд ямар нэг байдлаар мэдээлэл гардаг байдалтай байна.

Анхаарах асуудал:

- Монгол улсын газрын харилцааны салбарт хэрэглэж буй Мэргэжлийн программ хангамж болох AutoCad, ArcGIS, Land Manager, Erdas, ENVI программ хангамжуудыг лиценцтэй болгох шаардлагатай.

Зөвлөмж:

1. Сургалтын аргазүй, мэргэжлийн онцлогоос хамаарч хичээл тус бүр дээр харилцан адилгүй байгаа боловч багш нарын сонгож буй аргазүй тухайн хичээлийн хөтөлбөрт нийцэж байгаа талаар үнэлгээ хийх боломжтой.
2. Залуу багш нарын сурган заах аргазүйг дээшлүүлэх талаар ажиллах шаардлагатай байна.
3. Сургалтын аргазүйд зайн сургалтыг нэвтрүүлэх хүрээнд “Е” хичээл бэлтгэх, онлайн хичээлийг удирдан явуулах аргазүйд сургаж, нэвтрүүлж болох юм.
4. Багш нарын хичээлийн файл бүрдүүлэлт харилцан адилгүй байна. Мэргэжлийн багш нарын хичээлийн материал бүрдүүлэлт, сурган заах аргазүйн чиглэлээр туршлага судлуулж, хичээлийн хөтөлбөр агуулгыг бүрэн тусгасан ашиглах, тараах, материал бүхий файл бүрдүүлэлттэй болгох шаардлагатай.

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Сургалтын журамд суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээг, тухайн хичээлийн болон ерөнхий суурийн үнэлгээ, хөндлөнгийн шалгалт зэрэг байдлаар нарийвчлан тусгасан бөгөөд түүнийг баримтлан үнэлгээ хийж, мэдлэгийн түвшинг

тогтоодог байна. Мөн хичээлийн хөтөлбөр бүрт үнэлгээний бүтцийг тухайн хичээлийг агуулга, олгох мэдлэг чадвар, оюутны гүйцэтгэх даалгавар, бие даалтын ажлын хэмжээ бүтцээс хамааруулан ялгавартай тогтоосон байдаг байна. Үнэлгээний арга аргачлалыг хичээлийн хөтөлбөр тус бүрт тодорхой задаргаа байдлаар тусган баталгаажуулсан бөгөөд сургалтын үйл ажиллагаандаа мөрддөг байна.

- Оюутныг зохион байгуулж сургалтад идэвхтэй оролцох боломжийг олгож сургалтын идэвхитэй хэлбэрийн судалгааны аргуудыг өргөн ашигладаг байна. МУИС-ийн Сургалтын журамд суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээг хэрхэн хийхийг тодорхой тусгасан байдаг бөгөөд сургалтын явцад явцын болон улирлын шалгалтыг авдаг байна. Шалгалт авах хэлбэрийг багш нар хичээлийн агуулга, онцлогийг харгалзан уялдуулан сонгодог байна. Тухайн хичээлийг зааж буй багш нар багаар ажиллах, сонгосон объектын талаар хээрийн судалгаа хийж мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийж, материал боловсруулалт хийх зэргээр ажиллахад үнэлгээний янз бүрийн аргыг ашиглан оюутныг идэвхжүүлдэг байна.
- МУИС-ийн СиСи удирдлагын систем нь суралцагчийн үнэлгээ ил тод байх, найдвартай, шударга, ижил тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж чадсан байна. Мөн мэргэжлийн багш нар суралцагчийн үнэлгээг өгөхдөө ил тод, шударга, ижил тэгш байдлыг хангаж чадаж байгаад оюутны 87-91% нь хангалттай сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.
- Суралцагчдын гаргаж байгаа амжилтыг сурлагын үнэлгээ, чанар, амжилтын хувиар гаргасан байна. Суралцагчдын үнэлгээний голч дүн 2,5-аас дээш, 2-р түвшний оюутнуудын чанар 90%, амжилт 100%, 3-р түвшний оюутнуудын чанар 98%, амжилт 100%, 4-р түвшний оюутнуудын чанар 87%, амжилт 100% байна.

Зөвлөмж:

1. Оюутныг зохион байгуулж сургалтад идэвхтэй оролцох боломжийг олгож сургалтын идэвхитэй хэлбэрийн судалгааны аргуудыг өргөн ашигладаг байна. Багш тус бүрээр ямар хичээлийн агуулга, ямар онцлог дээр тулгуурлан тухайн аргыг сонгож байгаад үнэлгээ хийх шаардлагатай. Тухайн багшийн сонгосон арга тэр хичээлийн хөтөлбөрийн онцлогт нийцэж байгаа эсэхэд үнэлгээ өгч тэнхимээр хэлэлцвэл суралцагчийг бодитой үнэлэх нөхцөл бүрдэнэ.
2. Багш нар хичээл бүрээр тухайн хичээлийн хөтөлбөр, агуулгад тохирсон шалгалтын хэлбэрүүдийг сонгох боломжтой бөгөөд хичээл тус бүрийн календарьчилсан төлөвлөгөөндөө тусгах боломжтой.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Газар зохион байгуулалт хөтөлбөрөөр 1999 оноос хойш 390 төгсөгч бэлтгэгдэн гарсан ба нийт төгсөгчдийн 57 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна. Төгсөгчдийн дунд явуулсан судалгаанаас харахад төгсөгч нь ажлын байранд гарахад дунджаар 6 сар зарцуулж байгаа нь монгол орны нөхцөлд боломжийн гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол хийх, төгсөгчдөөс авах судалгааны анкетын загвар дээр ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол хийх,
- Ажил олгогч нараас авч байгаа судалгааны загварыг хөтөлбөрөөр олгох ур чадвар болон хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулах,
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн эерэг болон сөрөг үр дагаврыг хянах, судалгаа хийх,
- Төгсөгчдийн холбоо байгуулагдсан боловч үйл ажиллагаа нь тогтмол бус. Зохион байгуулж байгаа арга хэмжээгээ албажуулдаггүй.

Зөвлөмж:

1. Төгсөгчдийн холбоог тэнхим нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, эргэх холбоог сайжруулах,
2. Төгсөгч болон ажил олгогчдоос авч байгаа судалгааг тогтмолжуулж, тэдний саналыг хөтөлбөрийн шинэчлэлд тусгах, хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд ажил олгогчийн төлөөллийг оролцуулах,

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдөөс БХБЯ, ГЗБГЗЗГ, Орон нутгийн газрын албад, эрдэм шинжилгээ сургалтын байгууллага болон мэргэжлийн хувийн компанид удирдах болон гүйцэтгэх түвшний ажил гүйцэтгэж байна. Төгсөгч нар нь амжилттай ажиллаж ГЗБНЗЗН-ын хэлтсийн дарга, Нийслэлийн газрын албаны орлогч, Орхон аймгийн ГХБХБГ-ын дарга зэрэг удирдах ажил эрхэлж салбарын хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байна.
- Төгсөгчдийн дундаас Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 1, Алтан гадас 1, Хөдөлмөрийн хүндэт медаль 9, Газрын харилцааны тэргүүний ажилтан 18 төрсөн байна.
- Тус хөтөлбөрийн мэргэжлийн багш нар олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд амжилттай оролцдог. Салбарын нөлөө бүхий мэргэжлийн холбоод болон зөвлөлд ажиллаж байна.
- Газрын харилцааны салбар нь улс орны чухал салбар бөгөөд Яам, агентлаг, орон нутгийн газрын албад, сав газрын захиргаад, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, эрдэм шинжилгээ, сургалт судалгааны байгууллага болон мэргэжлийн газрын хэмжилтийн, төлөвлөлтийн, нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага зэрэг газарт төгсөгчид нь ажиллах боломжтой. Хөдөлмөрийн зах зээл нь өргөн хөрвөх боломж ихтэй салбар юм.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөн гарсан мэргэжилтнүүд хөдөлмөрийн зах зээлд амжилттай ажил үүргээ гүйцэтгэж байгаа боловч хөтөлбөрийн шинэчлэлээр мэргэжилтний эзэмших мэдлэг, ур чадварыг зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан өөрчлөх, сургалтад шинэ техник технологийг нэвтрүүлж байх шаардлагатай.
- Төгсөгчдийн гадаад хэлний болон монгол хэлний найруулгазүй, албан бичиг хөтлөлтийн шаардлага хангахгүй байгаа талаар ажил олгогчдоос гарч буй саналыг бодитой үнэлж хөтөлбөрт өөрчлөлт оруулах,
- Төгсөгчдийн дунд давтан сургах, ур чадвар олгох нэмэлт сургалтуудыг төлөвлөгөөтэй зохион байгуулах
- Амжилттай ажиллаж сургууль мэргэжлээ сурталчилж байгаа төгсөгчдөө алдаршуулах, тэнхимийн оюутны клубуудтэй холбож ажиллах

Зөвлөмж:

1. Ажил олгогчид болон амжилттай яваа төгсөгчдийг хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхитэй татан оролцуулах,

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр 1 гадаад оюутан төгссөн.
- Гадаад орны их дээд сургуультай хамтран оюутан солилцоо, дадлага хэрэгжүүлдэг.
- Улсын болон олон улсын уралдаан тэмцээнд оюутнууд амжилттай оролцдог.
- Хөтөлбөрөөр төгсөгчдөөс 5 доктор, 53 магистрын зэрэг амжилттай хамгаалсан байна.

Анхаарах асуудал:

- Гадны оронтой хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх
- Ахисан түвшинд олон улсын хөтөлбөрт суралцахад төгсөгч нартаа дэмжлэг үзүүлэх,

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн ахиц дэвшлийг тодорхойлох суурь мэдээллийн санг бүрдүүлэх,
2. Олон улсын түвшинд эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр үүссэн гадаад харилцааг сургалтын үйл ажиллагаатай уялдуулах, олон улсын богино болон урт хугацааны чадавхижуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх,

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь 2009-2010 оноос эхлэн багшийн мэдээллийн СИСИ программыг суурилуулан ажиллуулсан бөгөөд удирдлага, багш, ажилтан, суралцагч нар нь цахим хаягтай түүгээрээ дамжуулан эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, үйл ажиллагааны талаар бүх мэдээллийг авдаг.
- Мэргэжлийн тэнхимийн зүгээс үйл ажиллагаагаа сурталчилсан нээлттэй хаалганы өдөрлөгийг жил бүр зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Сургуулийн дотоод системээс гадна гадагшаа нийгэм рүү чиглэсэн мэдээллийн эх үүсвэрийг нээх,

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтын алба бүтцийг бий болгож ажилуулж эхэлж байна.
- Дотоод чанарын баталгаажуулалтын бодлого, хөтөлбөр боловсруулагдан удирдлагаар дэмжигдэн үйл ажиллагаа эхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дотоод баталгаажилтын талаар нэгдсэн ойлголт байхгүй бүтэц нэгжүүдийн дотоод уялдаа холбоо хангалтгүй.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ оролцогч талуудын санал хүсэлтийг тусгах нөхцөл бүрдээгүй.
- Хөтөлбөрийн өөрчлөлтүүдийн үр дүн, нөлөөлөлд дүн шинжилгээ хийдэггүй.
- Төгсөгчид болон ажил олгогч нартай хөтөлбөрийн шинэчлэл сайжруулалтын талаар эргэх холбоотой ажиллах

Зөвлөмж:

1. Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтын талаар багш, оюутан, төгсөгчдийг мэдээлэл аргазүйгээр хангах,
2. Байгууллагын дотоод баталгаажуулалтын алба болон хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах,
3. Хөтөлбөрт орж байгаа өөрчлөлтийн үндэслэл шаардлага, түүний үр нөлөөг хянах
4. Хөтөлбөрийн шинэчлэл өөрчлөлтөд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн оролцоо эрх үүргийг нэмэгдүүлэх,

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
3 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
4 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
5 Багшийн үйл ажиллагаа	+			
6 Сургалтын үйл ажиллагаа	+			
7 Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	+			
8 Чанарын үнэлгээ, баталгаажилт		+		Чанарын баталгаажилтын үйл ажиллагаа жигдрээгүй.
Дүгнэлт	Шинжээчдийн баг журмын дагуу тус хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлантай танилцаж, бодит байдалтай танилцан хөтөлбөрийн 8 шалгуураас 7 шалгуурыг бүрэн, 1 шалгуурыг хэсэгчлэн хангасан тул Хөтөлбөрийг магадлан итгэмжлэх боломжтой гэж дүгнэсэн.			

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Тийм	

Шинжээчийн дүгнэлт: Бүрэн хангасан

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

№	Нэр	Албан тушаал	Утас
1	П.Мягмарцэрэн	Тэнхмийн эрхлэгч	99119238
2	Б.Чинбат	профессор	99197825
3	В.Батцэнгэл	профессор	99117061
4	Г.Гантулга	Дэд проф	99995978
5	Б.Болормаа	Дэд проф	99093838
6	Ц.Базарханд	Ахлах багш	91999720
7	Ч.Болорчулуун	Ахлах багш	99843579
8	С.Мөнхнаран	багш	91991561
9	М.Цогтдулам	багш	99242560
10	Д.Даваадорж	Ахлах багш	99942934
11	Б.Оюунханд	багш	96028580
12	Ч.Заяа	багш	95777073
13	Ч.Ганпүрэв	багш	99094128
14	Н.Энхтуяа	багш	99012870
15	Э.Октябрь	ХТА	99695353
16	Э.Алтанболд	ХТА	95551595

II. Оюутны нэр

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Ч.Мэндбаяр	4	Голч 3,6	89989390
2	Б.Дүүриймаа	4	Оюутны байр	94608845
3	М.Хансүм	4	Дундговь	99664807
4	Ч.Балжинням	4	Өвөрхангай	96091444
5	Д.Бадамсүрэн	4	Хэнтий	94229359
6	Э.Лхасүрэн	4	Голч 2,9	85658720
7	Э.Анхбаатар	4	Голч 2,9	98201489
8	Ч.Дүүрэнбаяр	4	Оюутны холбоо	95449247
9	Д.Шайрийбуу	3	УБ голч 2,8	96122110
10	А.Очирхүү	3	Говь-алтай	96264297
11	Б.Сайнжаргал	3	Архангай голч 3,4	96200226
12	Д.Ууган-Эрдэнэ	3	УБ голч 2,4	94314656
13	М.Лхагвабаатар	3	УБ голч 3,0	91189918
14	Г.Ганбаяр	3	Оюутны байр	96228001
15	А.Мөнхзаяа	3	Оюутны байр	95483727
16	И.Бакытжан	2	Хэнтий	95785453
17	Б.Жавхлан	2	УБ голч 3,0	89178519
18	Ө.Мөнхзул	2	Дорнод	89768248
19	Ж.Энхбат	2	Өвөрхангай 3,5	89867447
20	Г.Пэрлиймаа	4	Сайн дурын байгууллага	96609363
21	Б.Орхон	4	УБ БЗД голч 3	99278888

III. Ажил олгогч


№	Овог нэрс	Байгууллага Албан тушаал	Утас
1	Д.Сайнбуян	Газарзүй –геоэкологийн хүрээлэн секторын эрхлэгч	91060503
2	Б.Галмандах	ГЗБГЗЗГ хэлтэсийн дарга	99064943
3	Ж.Мөнх-Эрдэнэ	ЧД-ийн ГА дарга	91912560
4	Д.Нямдаваа	НГА дэд дарга	94113346
5	Б.Загдсамбар	НГА дэд дарга	99116998
6	О.Цолмонбааатр	Парцел ХХК захирал	99102694
7	Б.Билгүүн	Газрын менежментийн үндэсний төв захирал	99447474
8	Д.Энх-Амгалан	Хот ба бүс нутаг төлөвлөгдийн холбоо тэргүүн	99819780
9	Г.Болдбаяр	Газар-эко ХХК захирал	99055720
10	Б.Мягмаржаргал	Геоботаник ХХК менежер	99926404
11	Д.Цолмон	Орхон аймгийн БХБГХГ- ын дарга	99367077
12	Б.Баяржаргал	Монголын мэргэшсэн үнэлгээчдийн нийгэмлэг захирал	99051017
13	Д.Бямбасүрэн	АТТП ХХК мэргэжилтэн	80951451

IV. Төгсөгчид

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага Албан тушаал	Утас
1	Ж.Мөнхцэрэн	2005	Геомастер ХХК мэргэжилтэн	99140355
2	Д.Бямбасүрэн	2010	АТТП ХХК мэргэжилтэн	80951451
3	А.Мөнх-Эрдэнэ	2006	Газарзүй – геоэкологийн хүрээлэн ЭШДА	99040270
4	Б.Нарангэрэл	2008	Газарзүй – геоэкологийн хүрээлэн ЭШДА	99006418
5	Ц.Ихбаяр	2008	ГЗБГЗЗГ мэргэжилтэн	99038665
6	Р.Отгончимэг	2004	ГЗБГЗЗГ мэргэжилтэн	86060598
7	Д.Мөнхсайхан	2011	Үндэсний хөгжлийн газар мэргэжилтэн	99078156
8	Н.Нямдорж	2011	Санхүүгийн зөвлөх ХХК Гүйцэтгэх захирал	80113777
9	Ч.Бурмаа	2012	Инженер геодези ХХК мэргэжилтэн	91902989

10	Э.Энхманлай	2012	Тэнгэр бурхны хишиг үнэлгээний ХХК менежер	99270305
11	Д.Батцэнгэл	2005	ЧД-ийн ГА мэргэжилтэн	88046776
12	М.Тэгшжаргал	2005	СБД-ийн ГА мэргэжилтэн	88084429
13	Ж.Энхчимэг	2013	ГЗБГЗЗГ мэргэжилтэн	89897010
14	Д.Зоригтбаатар	2008	БГД-ийн газрын алба мэргэжилтэн	88819916
15	М.Ууганбаатар	2013	НГА мэргэжилтэн	99802028
16	Д.Чанагнаянгар	2013	Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээ 7 буудал ажилтан	88014795
17	Н.Батболд	2004	ГЗБГЗЗГ мэргэжилтэн	99082304
18	Д.Оюунсүрэн	2005	ХУД ГА мэргэжилтэн	88078711
19	Л.Уранбилэг	2001	ХААИС, багш	96006675
20	Ш.Амартайван	2005	ЧД-ийн ГА мэргэжилтэн	96661671

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/


МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
14201 Улаанбаатар хот-46а у/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тогзруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: xas@num.edu.mn, nhr@xas.num.edu.mn

2018.03.05 № 70/186
Тастай 2018.02.26 -ны № 17 -Т


БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАЛ О.ЯНЖМАА ТАНАА

Албан бичгийн хариу хүргүүлэх тухай

Тус сургуулийн Газарзүйн тэнхимийн "Газар зохион байгуулалт" D053211 сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан болон сургалтын орчинтой танилцаж үнэлж дүгнэсэн шинжээчдийн багийн дүгнэлт бүхий 2018 оны 02 сарын 26-ны өдрийн 17 тоот албан бичигтэй танилцан гаргасан дүгнэлтийг зөв зүйтэй хэмээн хүлээн зөвшөөрч байна.

Мөн гаргасан дүгнэлтийн дагуу дараах материалыг та бүхэнд нэмэлтээр хүргүүлж байна. Үүнд: Өөрийн үнэлгээний багийн гишүүд тайлантай танилцсаны дүнд шалгуур 3.6 /Санхүүжилт/-д өгсөн анхааруулах асуудлыг гүйцэтгэн Газар зохион байгуулалтын хөтөлбөрөөр суралцагч нэг оюутны өртөг, зардлыг Хавсралт 1-ээр тооцож гаргав. Мөн шалгуур 4.4 /Суралцагчийн урамшууллын тогтолцоо/-д тэтгэлэгт хамрагдсан тус хөтөлбөрийн оюутнуудыг үндсэн тэнхимээсээ салгаж гаргадаггүй байсныг тусад нь түүвэрлэн Хавсралт 2-оор гаргалаа. Мөн түүнчлэн шинжээчийн багийн шалгуур 2.2-д анхаарах асуудал дээр зарим шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахыг санал болгосны дагуу 2018-2019 оны хичээлийн жилд МУИС-аас тус хөтөлбөрийн харъяа "Газар төлөвлөлт зураглал"-ын лабораторид хөрөнгө оруулалтын журмаар 150 сая төгрөгийн хоёр долгионы ЖПС сургалтын төхөөрөмж 8 ширхэгийг авахаар төсөвт суулгахаар санал өгөөд байна.

Хавсралт 1.4 хуудастай

ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО,
ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
БАЙГАЛИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ
ДОКТОР (PhD) 

ЦАМАРТАЙВАН

My.Doc.a bich, p.76

ҮII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/